



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2020 оны 27 дахь долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 6-р сарын 27-оос 7-р сарын 02-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 16 дахь дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Фитч агентлагийн 6-р сарын “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланд **дэлхийн эдийн засаг 2020 онд 4.6 хувиар агших** өмнөх сарын төсөөллийг хэвээр үлдээжээ. Үүнд БНХАУ, ХБНГУ, Өмнөд Солонгос, Австралийн эдийн засгийн өсөлтийн энэ оны төлөвийг өмнөх төсөөллөөс сайжруулсан бол Их Британи, Бразил, ОХУ, Мексик, Туркийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг өмнөхөөс бууруулав. Энэ оны 5 болон 6-р сарын макро үзүүлэлтүүд дэлхийн эдийн засгийн идэвхжил сэргэж байгааг илтгэж байна.

#### Хүснэгт 1. ОУ-ын байгууллагуудын 2020 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Төсөөлөл хийсэн байгууллага	Төсөөлөл хийсэн огноо	Дэлхийн эдийн засгийн өсөлт	БНХАУ-ын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүс өсөлт
Fitch	6/29/2020	<b>-4.6%</b>	1.2%	-5.6%	-8.0%
Atradius	6/25/2020	<b>-5.0%</b>	2.0%	-6.1%	-8.0%

- Зээл, бондын даатгал болон батлан даалт, авлага барагдуулах үйлчилгээг дэлхийн 50 гаруй улсад үзүүлдэг Atradius байгууллагын 6-р сарын “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланд тусгаснаар **дэлхийн эдийн засаг 2020 онд 5.0 хувиар**, хөгжингүй орнуудын эдийн засаг 6.6 хувиар **агших төлөвтэй байна**. Цар тахлаас үүдэлтэй хямрал нийлүүлэлтийн гинжин сүлжээнд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа тул **дэлхийн гадаад худалдаа 2020 онд 15 хувиар агшихаар тооцоолжээ**.
- Евро бүсийн** нэгдсэн PMI индекс энэ оны 5-р сард 31.9 байсан бол 6-р сард 47.5 болж **аж үйлдвэрлэлийн агшилт саарав**<sup>1</sup>. Дэд бүлгээр задалж үзвэл боловсруулах салбарын PMI индекс энэ оны 5-р сард 35.6 байсан бол 6-р сард 48.5 болсон, үйлчилгээний салбарын PMI индекс 5-р сард 30.5 байсан бол 6-р сард 47.3 болж, мөн агшилт нь саарчээ.
- Эдийн засгийн мэдрэмжийн индикатор, өндөр давтамжтай тоон мэдээллүүдээс үзэхэд **Евро-бүсийн эдийн засгийн сэргэлт "урт бөгөөд удаан" байхаар**

<sup>1</sup> IHS Markit-аас түүвэр судалгаанд суурилан тооцдог PMI индекс нь 50-аас дээш утга авбал тэлэлт, 50-с доош утгатай бол агшилтыг илтгэдэг.

**байгааг** Moody's агентлаг онцолжээ. “Google Mobility”-ийн мэдээллээс үзвэл хөл бөмбөгийн арга хэмжээ, дэлгүүр, зоогийн газрууд зэрэг үзвэр, үйлчилгээний газрууд нээгдэж эхэлснээр хэрэглээний зардал өссөн ч ихэнх улсад цар тахлын өмнөх түвшингөөс бага байна. Франц, Герман, Их Британи зэрэг улсуудад тавилга болон авто тээврийн хэрэгслийн онлайн дэлгүүрийн хандалт өсчээ. “Хөл хорио суларсантай холбоотойгоор хэрэглээ өссөн ч тодорхой бус байдал өндөр, орлогын тогтвортой байдал эргэлзээтэй, эрсдэл өндөр хэвээр байгаа тул өрхүүд зарлагаа танахыг илүүд үзэж Евро-бүсийн эдийн засгийн сэргэлт удаан байх магадлалтай” гэж Оксфорд Экономикс байгууллага үзэж байна.

- Mckinsey&Co байгууллагын 6-р сарын түүвэр судалгаагаар ирэх 6 сард эдийн засгийн төлөв ихэнх бүс нутгуудад өмнөх сарын түүвэр судалгаанаас сайжрах, өрхийн хэрэглээ, компаниудын ашиг нэмэгдэх хүлээлттэй байна.
- КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөө төсөөлснөөс илүү хүчтэй байж, **Их Британийн эдийн засаг 2020 оны эхний улиралд 2.2 хувиар агшлаа**<sup>2</sup>. Үүнд өрхийн хэрэглээ эхний 3 сарын байдлаар 2.9 хувиар буюу төсөөллөөс 1.2 нэгж хувиар илүү агшсан нь голлон нөлөөлөв. Харин өрхийн хуримтлал 2019 оны сүүлийн улиралд 6.6 хувь өсч байсан бол энэ оны эхний улиралд 8.6 хувиар өсөв. “Өрхийн зарлага буурч, хуримтлал нэмэгдэж байгаа нь хөл хорио бүрэн тавигдахад хэрэглээг огцом тэлж эдийн засгийн сэргэлтэд эерэг нөлөө үзүүлэх магадлалтай ч нөгөө талдаа ажлын байр, ажил эрхлэлтийн асуудал тодорхой бус байгаа нь эсрэгээрээ эдийн засгийн сэргэлтийг

удаашруулах эрсдэлтэй” гэж “EY Item Club”-ийн эдийн засгийн ахлах зөвлөх Ховард Арчер үзэж байна. Мөн тэрээр Их Британийн эдийн засаг хямралын өмнөх түвшинд эргэн очтол дор хаяж 2-3 жил шаардагдахаар байгааг онцолжээ. Их Британи бүх нийтийн хөл хориог 7-р сарын 4-өөс хэсэгчлэн цуцалж байна.

- **Герман улсад** ажилгүй иргэдийн тоо энэ оны 5-р сард 238'000-аар өсч, **ажилгүйдлийн түвшин 4-р сард 5.8 хувь байсан бол 5-р сард 6.3 хувьд хүрлээ**. Герман улс цар тахлаас үүдэлтэй ажилгүйдэлтэй тэмцэхийн тулд компаниудыг ажилчдаа түр хугацаанд чөлөөлөх эсвэл багасгасан цагаар ажиллуулахыг зөвлөж, харин орлогын тасалдлыг улсаас нь нөхөн олгож байна. Ингэснээр Герман улс нийт 10 сая гаруй ажлын байрыг хадгалж чаджээ. “Гэсэн ч ажилгүйдлийн хэмжээ өндөр, гадаад эрэлт муу, хэрэглээ буурсан зэрэг нь тус улсын эдийн засаг V хэлбэрийн сэргэлттэй байхаас нэгэнт өнгөрсөн гэдгийг харуулж байна” гэж “ING”-ийн эдийн засагч Карстен Брзеский хэллээ.
- **АНУ-д энэ оны 5-р сард иргэдийн орлого буурч, хэрэглээний зарцуулалт өсчээ**. АНУ-ын төсвөөс ажилгүйдлийн тэтгэмж болон бусад багц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний нөлөөгөөр иргэдийн сарын орлого 4-р сард өмнөх сараас 13.6 хувиар өссөн бол хэрэглээ 12.2 хувиар агшсан дүнтэй байв. Энэ оны 5-р сард хүн амын орлого өмнөх сараас 5 хувиар буурч, харин хөл хорио суларсантай холбоотойгоор хэрэглээний зардал 8.1 хувиар өсчээ. Үүнд голчлон автомашин, цахилгаан бараа, тавилга гэх мэт удаан эдэлгээтэй бараануудын бодит хэрэглээ өссөн нь нөлөөлөв. Өмнөх сард 12 хувиар агшаад байсан үйлчилгээний зардал 5-р сард 5.2

<sup>2</sup> Энэ нь 1979 оноос хойш ажиглагдаагүй том агшилт юм. Их Британийн “Үндэсний Статистикийн Газар”-

аас гаргасан тооцооллоор эдийн засаг I улиралд 2 хувиар агших хүлээлттэй байжээ.

хувиар өсч, хадгаламж 23.2 хувиар бууран түүхэн дээд агшилтыг үзүүлжээ.

### Эх сурвалж:

1. Fitch Ratings, [Global Economic Outlook: June 2020 - Coronavirus Disruption](#)
2. Atradius, [Global Economic Outlook - June 2020](#)
3. McKinsey & Company, [The coronavirus effect on global economic sentiment](#)
4. Их Британийн Үндэсний статистикийн газар, [Quarterly economic commentary: January to March 2020](#)

5. Deloitte: [Weekly global economic update June 2020](#)
6. Reuters: [Euro zone downturn eased in June, V-shaped recovery in doubt](#)
7. GfK: [Consumer climate in Germany continues to recover: Consumer activity reawakens after shock](#)
8. FT: [How quickly can the German economy recover?](#)
9. Bloomberg: [U.S. Consumer Spending Rebounded in May While Incomes Fell](#)

## 2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- БНХАУ-ын нийслэл Бээжин хотод **КОВИД-19-ийн шинэ тохиолдол** бүртгэгдсэнээр эдийн засгийн ирээдүйн төлөв, сэргэлтэд тодорхой бус байдлыг нэмэгдүүлсэн хэдий ч **сөрөг үр нөлөө багатай байхаар байна.** 1-р зэрэглэлийн хотууд болох Бээжин, Шанхай, Гуанжоу, Шенженд үл хөдлөх хөрөнгийн борлуулалт 6-р сарын 12-ны байдлаар цар тахлын өмнөх үеийн түвшингөөс нэмэгдсэн нь Ковид-19 дэгдсэнээс хойших хамгийн анхны өссөн үзүүлэлт байна.
- Шанхай-Шенжен 300 хөрөнгийн биржийн индексэд АА, АА+ зэрэглэлийн **бондуудын өгөөж нэмэгдэж**, 6-р сарын 19-ний байдлаар **цар тахлын өмнөх үетэй дөхөж очив.** Гэсэн хэдий ч компаниудын хөрөнгө оруулалтын таатай орчныг илэрхийлэх индикатор болох бондуудын нийт өгөөжийн хэмжээ 2019 оны 12-р сарын түвшингөөс доогуур хэвээр байна.
- **БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн салбарын орлого** 4-р сард 4.3 хувиар буурч байсан бол 5-р сард өмнөх оны мөн үеэс 6 хувиар өсөв. Энэхүү өсөлтөд аж үйлдвэрлэл 4, 5-р саруудад харгалзан 3.9%, 4.4%-иар өссөн, шаардлагатай бараа материалын үнэ буурч, компаниудын ашигт ажиллагаа сайжирсан нь голлон нөлөөлөв.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд болон хувийн компаниудын ашиг оны эхний 4 сард харгалзан 29% болон 17%-иар тус тус буурсан бол оны эхний 5 сард 18% болон 11%-иар тус тус буурсан нь эрч суларч байгааг илэрхийлж байна. Харин төрийн өмчит компаниудын ашигт ажиллагаа оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 46 хувиар буурсан бол оны эхний 5 сарын байдлаар 39 хувиар буурчээ. Төрийн өмчит компаниудын ашигт ажиллагаа төдийлөн сайжраагүй байгаа тул эдийн засгийг дэмжих бодлогын арга хэмжээ үргэлжлэх хүлээлттэй байна. Оны эхний 5 сард аж үйлдвэрийн салбарын орлого өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар буурсан нь дотоод эрэлт төдийлөн сэргээгүй байгааг илэрхийлж байна. Боловсруулах салбарын ашигт ажиллагаа оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар буурсан бол эхний 5 сард 16.6 хувиар буурч эрч нь багасав. Харин уул уурхайн салбар дахь ашигт ажиллагаа оны эхний 4 сард 35.2 хувиар буурсан бол эхний 5 сард 43.6 хувиар буурч эрч нь нэмэгдлээ.

- **БНХАУ-ын аж үйлдвэрийн Caixin PMI индекс 5-р сард 50.7 хүрсэн бол 6-р сард 51.2 хүрч нэмэгдэв.** Үүнд эрэлт нэмэгдэн, шинэ захиалгын тоо 1-р сараас хойш анх удаа 50-ыг давсан нь нөлөөлжээ.

- БНХАУ-ын аж үйлдвэрийн албан ёсны PMI индекс 5-р сард 50.6 хүрсэн бол 6-р сард 50.9 хүрчээ. Үүний зэрэгцээ албан ёсны аж үйлдвэрийн-бус PMI индекс 6-р сард хүлээлтээс дээгүүр 54.4 хүрч 11-р сараас хойших хамгийн өндөр үзүүлэлттэй байв. Энэ нь БНХАУ-ын нийслэл Бээжин хотод шинэ тохиолдлууд илэрснээр авч хэрэгжүүлсэн хязгаарлалтууд төдийлөн өргөн хүрээтэй байгаагүй болохыг харуулж байна.

#### Эх сурвалж:

1. Bloomberg, China Insight: Recovery Slows, virus flares up – dashboard
2. Bloomberg, China Insight: Tighter liquidity, manageable risks-gauges
3. Bloomberg, China React: Caixin PMI rise shows external support kicking in
4. Bloomberg, China React: Industrial Profits on soft ground given weak demand
5. Bloomberg, China React: PMIs get export lift, weather Beijing Outbreak

### 3 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ГОЛЛОХ ИНДЕКС ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

#### USD, S&P:

- 2020 оны 2-р улирлын туршид ам.доллар бусад валютын эсрэг чанга байж DXY индекс 98.9-100.7 түвшинд арилжаалсан байна. ЗГ-аас хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөө тодорхойгүй, вирусийн эрсдэл өндөр байсан үед эрсдэл бага валют болох ам.долларын эрэлт өндөр байв.
- АНУ-ын макро эдийн засгийн үзүүлэлт сайжирч эрсдэл буурах дохиогоор ам.долларт хийгдэх хөрөнгө оруулалт буурснаар 6-р сарын дундуур ам.долларын ханш суларч 95.9-97.7 түвшинд арилжаалсан байна.
- Ийнхүү тодорхой түвшинд хэлбэлзсээр буй нь вирусийн 2-р давлагааны эрсдэлийг зах зээлд оролцогчид хараахан тодорхойлоогүй байгааг илтгэж байна.

#### JPY, Nikkei:

- Тайлант хугацааны эцэст иен ам.долларын эсрэг 0.6%-иар суларч 107.51 хүрлээ.
- Хувьцааны индекс сарын өмнөх үеэс 2.4%-иар буурсан ба Төв банкны судалгаагаар бизнесийн орчны итгэлийн түвшин 2009 оны хямралаас хойших хамгийн доод түвшинд хүрснийг онцолсон байна.

#### EUR:

- Тайлант хугацаанд евро ам.долларын эсрэг 0.6%-иар чангарч, 1.12 түвшинд хүрэв.
- Евро бүсийн эдийн засгийн голлох үзүүлэлтүүд аажмаар сайжирч, Герман, Франц зэрэг бүсийн томоохон эдийн засагтай орнууд Ковид-19 вирусийн дараах эдийн засгийн өсөлтийг дэмжих хөтөлбөрөө танилцуулаад байгаа нь ханшийн өсөлтөд эерэгээр нөлөөлөв.


### CNY:

- БНХАУ-ын эдийн засаг идэвхжиж, хөрөнгийн урсгал сайжирснаар юанийн ханш тогтворжиж, тайлант хугацааны турш юань ам.долларын эсрэг 0.3%-иар чангарч 7.07 түвшинд хүрлээ.
- Эдийн засгийн идэвхжилтийн нөлөөгөөр Hang Seng болон Шанхайн нэгдсэн индексүүд тус бүр 1.9% болон 11.0%-иар өслөө. Хонг Конгт төвлөрсөн Hang Seng индексийн өсөлт шинэ хууль баталж, хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор нам дор байлаа.

### GBP, FTSE:

- Тайлант хугацаанд фунт стерлинг ам.долларын эсрэг 1.1%-иар чангарч, 1.25 түвшинд хүрлээ. Англи Улсын үйлдвэрлэлийн PMI 6-р сарын байдлаар 50.1 гарч өсөлтийг илтгэх болсон нь ханш өсөлттэй байх үндсэн нөхцөл болов.

Ам.долларын DXY индекс



Улсын Онцгой комиссын 2020 оны XXV ээлжит хурал 6-р сарын 30-ны өдөр болж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

- Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрийг дуустал сунгахаар шийдвэрлэж, Засгийн Газрын тогтоолоор баталгаажуулав.
- Бакалаврын зэрэг горилогчдоос авах Элсэлтийн ерөнхий шалгалтыг 2020 оны 7 дугаар сарын 2-оос 5-ны өдрүүдэд орон даяар зохион байгуулахыг зөвшөөрлөө. Шалгалтыг зохион байгуулахдаа Монгол Улсын Засгийн Газар, УОК-ын тогтоолоор баталгаажиж, ЭМЯ-аас боловсруулан гаргасан халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын бүхий л дэглэмийг сайтар сахиж, ажиллахыг үүрэг болголоо.
- Хөрш хоёр орноос 700-аад иргэнийг Замын-Үүд, Алтанбулаг боомтуудаар татан авахаар шийдвэрлэсэн бол 7 дугаар сард нийт 10-12 захиалгат нислэг үйлдэх саналтай байгаагаа Гадаад харилцааны яамны Консулын газраас танилцуулж зарим зөвшөөрлийг олгов.

- Нийтийг хамарсан зарим үйлчилгээнүүдийг 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс үе шаттай нээх чиглэлээр эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргаж ажиллахыг аймаг, дүүргийн засаг дарга нарт зөвшөөрлөө. Иймд хүүхдэд компьютер тоглоомоос бусад тоглоомын үйлчилгээ үзүүлдэг хүүхдийн тоглоомын газар, сургалт, амралтын зуслан, кино театр, үзвэр үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд, театр, чуулга, ресторан, уушийн газар, караоке, шашин номын газруудыг халдвар хамгааллын шаардлагыг хангасан тохиолдолд үйл ажиллагаагаа нээх боломжтой болж байна. Ингэснээр зөвхөн нийслэлд 960 аж ахуйн нэгжийн 10 мянга гаруй ажлын байр идэвхжих юм.
- Нийтийг хамарсан жагсаал цуглаан хийх, спортын томоохон арга хэмжээ зохион байгуулахыг болон диско бар, бүжгийн цэнгээний газруудыг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг бууртал нээхгүй байхаар шийдвэрлэлээ

#### *Эх сурвалж:*

Монгол Улсын Засгийн газар, [Үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг үе шаттай нээхийг зөвшөөрөв](#)

**5 ХҮҮ, БОНД, ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАГДАЖ БУЙ МУ-ЫН БОНД, ХУВЬЦАА**

**LIBOR:**

- Тайлант хугацаанд бүх хугацааны LIBOR хүү 6 хүртэл суурь нэгжээр буурав. Энэ нь оны эхнээс 160 хүртэл суурь нэгжээр буурсан үзүүлэлт юм.

**АНУ-ын ЗГҮЦ:**

- Цар тахлын тархалт эрчимтэй нэмэгдэж байгаатай холбоотойгоор зах зээлд эрсдэлгүй хөрөнгө оруулалтын эрэлт нэмэгдэж, АНУ ЗГҮЦ-ны үнэ өсөлттэй байв.
- Улмаар 10 жилийн хугацаатай ҮЦ-ны өгөөж 0.67%, 2 жилийн хугацаатай ҮЦ-ны өгөөж 0.15% хүрч, 3 хүртэлх суурь нэгжээр буурав. ХНБ-ны бодлогын хүү нам дор түвшинд тогтвортой байв.

Хүснэгт 1: Голлох хүүгийн өөрчлөлт

Индекс	Сүүлийн хаалт	14 хоног Δ	1 сар Δ	1 жил Δ	Оны эх Δ
Fed Overnight	0.08	▲ 0.00	▲ 0.03	▼ -2.31	▼ -1.47
Libor 1 week	0.10	▼ -0.01	▲ 0.01	▼ -2.29	▼ -1.49
Libor 1 month	0.16	▼ -0.03	▼ -0.02	▼ -2.20	▼ -1.57
Libor 3 month	0.30	▼ 0.00	▼ -0.03	▼ -1.98	▼ -1.60
Libor 6 month	0.37	▼ -0.06	▼ -0.12	▼ -1.84	▼ -1.54
Libor 12 month	0.54	▼ -0.04	▼ -0.09	▼ -1.64	▼ -1.46
Shibor O/N	1.36	▼ -0.77	▼ -1.14	▲ 0.49	▼ -0.08
Shibor 1 Week	1.98	▼ -0.17	▼ -0.63	▼ -0.17	▼ -0.45
Shibor 1 Month	2.01	▼ -0.04	▼ -0.80	▼ -0.48	▼ -0.89
Shibor 6 Month	2.19	▲ 0.05	▼ -0.72	▼ -0.57	▼ -0.83
Shibor 1 Year	2.38	▲ 0.08	▼ -0.60	▼ -0.72	▼ -0.71
US 2Y Treasury	0.15	▼ -0.03	▼ -0.05	▼ -1.61	▼ -1.42
US 10Y Treasury	0.67	▼ -0.02	▼ -0.23	▼ -1.28	▼ -1.21
Japan 2Y Treasury	-0.14	▲ 0.02	▲ 0.00	▲ 0.08	▼ -0.01
Japan 10Y Treasury	0.02	▲ 0.01	▼ -0.02	▲ 0.18	▲ 0.04
Bund 2Y Treasury	-0.69	▼ -0.01	▼ -0.09	▲ 0.07	▼ -0.08
Bund 10Y Treasury	-0.43	▼ -0.02	▼ -0.16	▼ -0.05	▼ -0.21
ECNIA	-0.46	▼ 0.00	▼ -0.01	▼ -0.10	▼ -0.01

**SHIBOR:**

- Овернайт SHIBOR хүү тайлант хугацаанд 77 суурь нэгжийн уналттай байсан бол 6 сараас дээш хугацаатай SHIBOR хүүний түвшин тогтвортой байж 5-8 суурь нэгжээр өслөө. Гэсэн ч SHIBOR хүү оны эхнээс бүх хугацаанд 89 хүртэл суурь нэгжээр буураад байна.

**Бондын мэдээлэл:**

- Тайлант хугацаанд Монгол Улсын гадаад бондуудын үнэ 8.6% хүртэл өсч, өгөөж 14 хүртэл суурь нэгжээр буурав.
- Ам.долларын өгөөж тогтвортой байхад Монгол Улсын ам.долларын ҮЦ-ны өгөөж буурч буй нь хөрөнгө оруулалтын орчин сайжирч, зээлийн эрсдэл буурч байгааг илтгэж байна.

Хүснэгт 2: Дотоодын үнэт цаасны өөрчлөлт

Үнэт цаас	Сүүлийн хаалт	Өөрчлөлт Δ			
		14 хоног	Сар	Жил	Оны эх
ЗГҮЦ 5 жил	\$113.3	▲ 8.6%	▲10.5%	▲ 2.0%	▼ -4.9%
ЗГҮЦ 10 жил	\$99.8	▲ 0.0%	▲4.6%	▼ -1%	▼ -3%
ЗГҮЦ 5 жил (2021)	\$104.0	▼ -0.3%	▲1.4%	▼ -6%	▼ -4.9%
ЗГҮЦ 7 жил	\$108.3	▲ 0.4%	▲6.7%	▼ -4.4%	▲ 0.4%
ЗГҮЦ (Гэрэгэ)	\$100.4	▲ 0.0%	▲5.0%	▼ -1.6%	▼ -3.0%
ХБ 5 жил (2023)	\$96.4	▼ -0.1%	▲10.2%		
Turquoise hills (CAD)	\$0.8	▲ 7.9%	▼ -4%	▼ -39%	▲ 0.7%
ММС (HKD)	\$0.4	▲ 19.4%	▲ 23%	▼ -59%	▼ -34.8%
<b>Өгөөж</b>					
ЗГҮЦ 10 жил (Чингис)	5.2	▼ -0.01	▼ -1.94	▲ 0.44	▲ 1.04
ЗГҮЦ 5 жил (Мазаалай)	4.5	▲ 0.08	▼ -2.39	▲ 0.52	▲ 1.59
ЗГҮЦ 7 жил (Хуралдай)	6.2	▼ -0.14	▼ -2.09	▲ 0.70	▲ 1.20
ЗГҮЦ 6 жил (Гэрэгэ)	5.5	▼ -0.02	▼ -1.84	▲ 0.44	▲ 0.99
ХБ 5 жил (2023)	7.6	▲ 0.00	▲ 0.00		